

Халдварт өвчин судлалын Үндэсний төвөөс Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний зааврыг хэрэгжүүлэх мэргэжил арга зүйн сургалтыг 2017 оны 09 сарын 21-ний өдөр зохион явууллаа.

Халдварт өвчин судлалын Үндэсний төвөөс Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний зааврыг хэрэгжүүлэх мэргэжил арга зүйн сургалтыг 2017 оны есдүгээр сарын 21-ний өдөр зохион явууллаа. Сургалтад нийслэл, дүүргийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн нэгдлийн халдварт өвчин, сүрьеэгийн тусламж үйлчилгээ хариуцсан эмч, мэргэжилтнүүд оролцож, Эрүүл мэндийн сайдын 2017 оны наймдугаар сарын 3-ны одрийн Сүрьеэгийн тусламж, үйлчилгээг сайжруулах тухай А/306 тоот тушаалтай танилцаж, уг тушаалаар батлагдсан Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний зааварын тухай дэлгэрэнгүй мэдээлэл сонсч, уг зааврыг хэрхэн хэрэгжүүлэх талаар мэргэжил арга зүйн зовлогоо авцгаалаа.

Манай улсад нохон үржихүйн болон идэр залуу, ходолморийн бүтээмжит насны залуучуудын дунд сүрьеэгийн өвчлөл, нас баралт ондор байхын зэрэгцээ сүүлийн жилүүдэд эмэнд дасалтай сүрьеэ нэмэгдэж байгаа нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал боллоо. Энэ нь улс орны хөгжил, хувь хүний эрүүл мэнд, эдийн засаг, амьдралын чанарт соргоор нолоолох хэмжээнд нийгэм хүрч болзошгүй байна.

Иймд энэ оны эхээр Засгийн газраас батласан Халдварт өвчноос сэргийлэх, хянах Үндэсний хотолборийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2017 оны наймдугаар сарын 3-ны одор гаргасан Сүрьеэгийн тусламж, үйлчилгээг сайжруулах тухай А/306 тоот тушаал нь ихээхэн ач холбогдолтой юм. Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан дээр дурдсан журмыг хэрэгжүүлснээр сүрьеэгийн халдварыг Тогтвортой хөгжлийн зорилтын хэмжээнд хүртэл бууруулах нохцол бүрдэнэ эмч, мэргэжилтнүүд үзэж байна.